

Монголын Хөдөөгийн Хөгжлийн Нам

Хаяг: Монголын Хөдөөгийн Хөгжлийн Нам  
Ш/Х-21/787  
Улаанбаатар

Утас: 633601

# Монголын Хөдөөгийн Хөгжлийн Намын баримтлах үзэл баримтлал



МХХН-ийн анхны  
Их хурлаар баталсан

1999 оны 2-р сарын 10 -ны өдөр

МХХН бол Монгол Улсыг өнөөгийн хямралаас бодитойгоор гаргаж улс орныг хөгжил дэвшлийн замд түүнийг оруулахын тулд хүн ард нь бүх талаар хэвийн амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилго бүхий улс төрийн хүчин мөн. Намын баримтлах гол үзэл санаа бол "Монгол Улсын хөгжлийн эх үндэс нь хөдөөгийн хөгжил мөн." гэсэн түүнийг баримтлал юм.

МХХН нь үндсэн зорилгодоо хүрэхийн тулд нийгмийн бодлогын хүрээнд төрийн оролцоог хүчтэй болгохыг үндэслэн ажиглагандаа гол зарчим болгоно. Өнөөгийн Монголын нийгмийг архагшсан хямралаас гаргахын тулд дэлхийн нийгмийн улс орнуудын өнөөгийн хөгжлийг бодитой харж монгол орны эзлэх байр суурийг эрүүл саруул ухаанаар дүгнэх явдал нь үндэсний дэвшлийн бодлогын суурь нь хөдөөг хөгжүүлэх төрийн цэгцтэй бодлого байх болно.

## Нэг. Эдийн засгийн хүрээнд

- а) Монгол орныг эдийн засгийн хямралаас гаргах гол арга зам бол өөрөө өөртөө туслах үйл ажиллагааг бодит үйлдвэрлэлээр хэрэгжүүлснээр хоршоо дундын жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэн үйлдвэрлэгчид, хэрэглэгчдийн эрх зүйн нийцсэн шударга өрсөлдөөний орчинг бүрдүүлэх;
- б) Өөрөө өөртөө туслах үйл ажиллагааг хэрэгжүүлснээр эдийн засгийн нөөцийн өсөлт, ажил эрхлэлт, үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын асуудал нэгэн зэрэг шийдвэрлэгдэнэ;
- в) Төрийн зах зээлийн зохицуулалтын механизмыг үндэсний үйлдвэрлэлээ хамгаалах татварын, гааль, худалдааны бодлогыг оновчтой явуулахад чиглүүлнэ;
- г) Хөдөөгийн хөдөлмөрчид үйлдвэрлэлээ эдийн засгийн хувьд бие даан хөгжүүлэхийн тулд Хөдөө Аж Ахуйн бүтээгдхүүний үнийн түвшинг нийт улс орны хэмжээнд өөрсдөө барих тогтолцоог бүрэлдүүлнэ;
- д) Хөдөөгийн хөдөлмөрчдийн орон нутгийн нийгэм, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэх зохистой арга замын нэр хэрхэлээр хөршөөлөл гэж үзнэ;
- е) Төр татварын уян хатан бодлогоор хөдөөгийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжинэ;
- ё) Аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зах зээлийн чөлөөт шударга өрсөлдөөний нөхцөл боломжоор хангахын тулд төв болон орон нутгийн засаг захиргааны анхан шатны нэгж бүрийг хамарсан мэдээллийн нэгдсэн сүлжээгээр хангах үүргийг төр хариуцна;
- з) Дэлхийн улс орнуудын хөгжлийн аюулгүй байдлын баталгаа бол хүн амаа экологийн хувьд цэвэр бүтээгдхүүний хангах бодлого хэрэгжиж байгаа өнөө үед байгалийн хүчин зүйлүүдийн тэнцвэрт байдлыг тогтворжуулж үйлдвэрлэл нөхөн сэргээхэд чиглэгдсэн бодлого баримтлана;
- ж) Хөдөөг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг уламжлалт аж ахуйн өвөрмөц арга технологид тулгуурлан маркетинг менежментийг боловсруулна.  
Хөтөлбөрт:
  - Мал аж ахуйн салбарт
    - Малын удмын сан ба эрүүл мэндийн тухай хуулийг зах зээлийн эдийн засгийн нөхцөлд нийцүүлэн өөрчилж эмнэлэг ба мал зүйн албадыг тусгаарлан төрийн хяналтын дор ажиллуулах;
    - Бэлчээрийн ашиглалт, уст цэг, усжуулалт, тэжээл үйлдвэрлэлийг төрийн хяналтанд байлгаж тэдгээрийг ашиглалт, эзэмшилт, өмчлөлийн тухай хууль боловсруулах;
    - МАА-н салбарын аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааг тодорхойлох үзүүлэлтүүдийг бодитоор тэргүүлэх аж ахуйн нэгжийг тодорхойлох;
    - МАА-н үйлдвэрлэлийг эрсдлээс хамгаалах зээл даатгалын тогтолцоог хөдөөгийн хөдөлмөрчдийн банкны бус ажиллагаа явуулах санхүүгийн аж ахуйн нэгжүүдээр дамжуулан бүрэлдүүлэх, улсын хадлан тэмдэглэх зохистой сүлжээ бий болгох;
  - Газар тариалангийн салбарт
    - Газар тариалан эрхлэх онцлогийг харгалзан төрийн ба хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн эдэлбэр гаргахыг ашиглах, эзэмших, өмчлөх эрхийг үндэсний аюулгүй байдалд нийцүүлэн тодорхойлох;
    - Газар тариалангийн салбарын аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааг тодорхойлсон үзүүлэлтүүдийг бодитоо тогтоон аж ахуйн нэгжийг тодорхойлох, газар тариалангийн онцлогт тохирсон шинэ техник технологийг нэвтрүүлэх;
    - Газар тариалангийн үйлдвэрлэлийн зохистой бүтцийг тогтоон аж ахуйн нэгжүүдийн хүчин чадал, байршил зэргийг харгалзан төрөөс зээл санхүү, татварын уян хатан бодлого баримтлах;
    - Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрсдэлээс хамгаалах зээл, даатгалын тогтолцоог төрийн болон хувийн хөдөлмөрчдийн банкны бус үйл ажиллагаа явуулах санхүүгийн байгууллагуудаар дамжуулан бүрэлдүүлэх;
    - Улсын баталгаат үрийн санг байгуулах;

## Хоёр. Нийгмийн бодлого, шинжлэх ухаан, соёлын хүрээнд;

- а) Монгол үндэстэн болон монгол хүн нэг бүрийн амьдралын баталгаажих үндэс бол нийгмийн баялагын шударга хуваарилалт хүн бүрийн хөдөлмөр хүчин зүтгэл, бүх нийтийн чанд сахилга, үндэсний эв нэгдэл юм;
- б) Монгол үндэстний оршин тогтнох үндэс болох эрүүл удмын сан, монгол хүний эрүүл чанар чансалт бодлогын тулгын чулуу гэж үзнэ;
- в) Хүн амын амжиргааны түвшин, боловсрол, эрүүл мэндтэй холбоотой бүхий л үйлчилгээний асуудлууд чанар өндөр түвшинд байх ёстой гэсэн зарчим зөвхөн нийгмийн даатгалын болон татварын оновчтой бодлогын үр шийдэгддэг байх ёстой гэж үзнэ;
- г) Монгол хүн аль ч талаар доройтохгүйгээр хөгжин боловсорч байх эх үндэс бол үндэсний соёлын үнэт зүйлүүдийг хадгалж хойч үедээ тасралтгүй өвлүүлэх хэвийн тогтолцоог бүрдүүлэх;
- д) Хөдөө аж ахуй дахь өнөөгийн хоршооллын хөгжлийг дэлхийн хоршооллын хөгжлийн түвшинд хүргэх зорилготой эрмэлзэнэ;
- е) Хөдөө аж ахуйд орчин үеийн шинэ техник технологийг нэвтрүүлэх үйл явцыг эрчимжүүлж хөдөө аж ахуйн шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн холбоог үр ашигтай байлгах зорилгоор хавсрага судалгаанд суурь судалгааг түлхүү анхаарна;
- ё) Хөдөө аж ахуйд боловсон хүчний зохистой бодлого явуулахад түлхүү анхаарна. Үүний тулд одоо үйлдвэр хэмжээнд нэгэнт бэлтгэгдсэн бөгөөд бэлтгэгдэж байгаа боловсон хүчний хүрээнд мэргэжил боловсролын системтэйгээр дээшлүүлэх замаар хөдөө аж ахуйг хөгжүүлэх боловсон хүчний үндэсний элитийг төлөвшүүлнэ;
- з) Хөдөө аж ахуйн салбарт ажиллагсадын залгамж холбоог алдагдуулахгүйн тулд боловсролын тогтолцоог хамарсан уялдуулан зохицуулж үе дамжсан халааг бэлтгэхэд анхаарна;

- 2.2.5. Намын байгууллагаас өөрийнх нь тухай хэлэлцэхэд биеэр оролцох  
 2.2.6. Намын бодлого, үйл ажиллагааны талаар мэдээлэл авах  
 2.2.7. Тус намын гишүүний хувьд өмгөөлүүлэх, эрхээ хамгаалуулах  
 2.2.8. Намын гишүүнээс түдгэлзэх, намаас өөрийн хүсэлтээр гарах

### 2.3. Гишүүний үүрэг

- 2.3.1. Намын анхан шатны аль нэгэн байгууллагад харьяалагдаж, намын үйл ажиллагаанд идэвхтэй оролцон үзэл баримтлал, шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, дүрмийг дагаж мөрдөх  
 2.3.2. Намын гишүүн улс төрийнхөө эрх ашгийг ямагт дээдлэх  
 2.3.3. Намын болон намын гишүүний нэр хүнд, үйл ажиллагааг хүндлэн дээдэлж намтай холбоотой аливаа үйл ажиллагааны төлөө хариуцлдага хүлээх

#### Гурав. Намын зохион байгуулалт

##### 3.1. Анхан шатны байгууллага

- 3.1.1. МХХН-ын үзэл баримтлалыг дэмжсэн 9-с дээш гишүүн анхан шатны нэгж үүр, 15-с дээш үүр нийлж хурал байгуулж болно.  
 3.1.2. Намын анхан шатны нэгжийн удирдах дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал, хороонд бага хурал байна.

##### 3.2. Удирдах байгууллага а) Их хурал

- 3.2.1. Намын эрх барих дээд байгууллага нь Намын их хурал байх бөгөөд 4 жилд нэгээс доошгүй удаа хуралдана.  
 3.2.2. Намын анхан шатны үүр, хороодоос сонгогдсон төлөөлөгчтэй байх бөгөөд Их хурлын Мандатын комиссионоос олгогдсон мандаттай гишүүд таслах эрхтэй оролцоно.  
 3.2.3. Намын Их хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.  
 - Намын эрхэмлэх үнэт зүйл, мөрийн хөтөлбөр, намын дүрмийг батлах  
 - Намын Бүгд хурал, Удирдах зөвлөл, Хяналтын Зөвлөл сонгож батлана.  
 - Удирдах зөвлөлийн санал болгосноор намын даргыг батлах  
 - Ээлжит бус Их хурал хуралдуулах шийдвэрийг Удирдах Зөвлөлийн ердийн олонхын саналаар намын Бүгд хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

##### б) Бүгд хурал

- 3.2.4. Намын Бүгд хурал нь Их хурлаас сонгогдсон 51 гишүүнтэй байх бөгөөд жилд нэгээс доошгүй удаа хуралдана  
 3.2.5. Намын бүгд хурал нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.  
 - Намын дарга, Удирдах Зөвлөл, Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны тайлаг сонсож хэлэлцэх  
 - Намын их хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны чиглэл тодорхойлох  
 - Сонгуульд оролцох сонгуулийн хөтөлбөр хэлэлцэж батлах  
 - Сонгуульд нэр дэвшигчийг дэвшүүлэх  
 - Ээлжит ба ээлжит бус Их хурал хуралдуулах товыг тогтоох  
 - Шаардлагатай үед намын дүрэм, үзэл баримтлалд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх

##### в) Удирдах Зөвлөл

- 3.2.6. Удирдах зөвлөл их хурлаас сонгогдсон 15 гишүүнтэй байна.  
 3.2.7. Намын дарга Удирдах зөвлөлийн дарга байна.  
 3.2.8. Удирдах Зөвлөлийн хурлыг Удирдах зөвлөлийн гишүүдийн ердийн олонхын саналаар хуралдуулна.  
 3.2.9. Удирдах зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.  
 - Намын дээд байгууллагын эрх олгосон асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх  
 - Төр засгийн бодлого, үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар намын нэрийн өмнөөс шийдвэр гаргах  
 - Ээлжит бус их хурлыг зарлан хуралдуулах саналыг Бүгд хуралд санал оруулах  
 - Намын даргын нэрийг дэвшүүлж Их хурлаар батлуулна.  
 - Намын үйл ажиллагаа зохион байгуулалттай холбогдол бүхий тусгай журам, баримт бичгүүдийг боломжтой мөрдүүлэх  
 - Ерөнхий нарийн бичгийн даргыг томилж ажиллуулна  
 - Намын хөрөнгө санхүүгийн асуудлыг хариуцна.

##### г) Хяналтын ерөнхий зөвлөл

- 3.2.10. Намын Хяналтын зөвлөл 5 гишүүнтэй байна.  
 3.2.11. Намын үзэл баримтлал, дүрмийн хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих, төр засгийн бодлого, үйл ажиллагааны талаар мэдээлэл авах, намны байгууллагад сонгогдсон гишүүний ёс зүй, үйл ажиллагааны талаар дүгнэлт гаргах, шийдвэрлүүлэх  
 3.2.12. Намын гишүүд дэмжигчдийн санал хүсэлтийг шийдвэрлэсэн байдлыг шалгах, гишүүдээс гаргасан саналыг хянан барагдуулах  
 3.2.13. Намын хяналтын үйл ажиллагаатай холбогдон гарсан зардлыг нам хариуцна.  
 3.2.14. Шаардлагатай үед Хяналтын зөвлөл нь Бүгд хурлыг зарлан хуралдуулах асуудлыг Удирдах зөвлөлд зөвшилцөж шийдвэр гаргана.  
 3.2.15. Хяналтын зөвлөл нь улиралд нэгээс доошгүй хуралдана.

##### д) Намын дарга

- 3.2.16. МХХН-ын дарга нь тус намын үйл ажиллагааг бүхэлд нь зохион байгуулж, их хурлын шийдвэрийн бодлого, үйл ажиллагааны эцсийн үр дүнг намын бүх гишүүдийн өмнө хариуцна.  
 3.2.17. Намын үйл ажиллагаатай холбогдсон хөрөнгө санхүүг захиран зарцуулах эрхийг Удирдах зөвлөлд журмын дагуу хэрэгжүүлнэ  
 3.2.18. Намын үйл ажиллагаатай уялдаж дэд дарга ажиллуулах шаардлага гарвал Удирдах зөвлөлтэй зөвлөлдөж Удирдах зөвлөлийн гишүүдээс дэд даргыг томилж ажиллуулна  
 3.2.19. Намыг гадаад дотоодод төлөөлнө  
 3.2.20. Намын даргын үүргийг шаардлагатай үед дэд дарга, ерөнхий бичгийн даргын аль нэг нь гүйцэтгэнэ.

##### е) Намын ерөнхий нарийн бичгийн дарга

- 3.2.21. Ерөнхий нарийн бичгийн даргыг Удирдах зөвлөл томилно.

Ерөнхий нарийн дарга намын өдөр тутмын үйл ажиллагааг хариуцна  
Ерөнхий нарийн даргын газар, газар нь албад, хэлтсүүдтэй байж болно  
Ерөнхий нарийн бичгийн даргын аппарат намын санхүүгийн үйл ажиллагааны тайланг улирал, жилээр гаргаж хяналтын зөвлөлд тайлагнана

Дөрөв. Санхүүжилт

Намын санхүү нь гишүүний татвар, хувь хүн, байгууллагын хандив, хуулиар зөвшөөрөгдсөн бусад орлогоос бүрдэнэ.  
МХХН-намын өөрөө өөрийгөө санхүүжүүлэх байгууллагыг Удирдах зөвлөлийн шийдвэрээр байгуулж болно

\* \* \* \* \*

Үндсэн дүрэм, тусгай журманд өөрөөр заагаагүй бол намын бүх шатны байгууллагын ирц ердийн олонхи байх ба шийдвэрийг ердийн олонхоор батална. Санал хураалт ил буюу нууц хэлбэртэй байна.

### Монголын нийгмийн өнөөгийн байдал ба хөдөөгийн хөгжлийн талаархи үзэл баримтлал

(ХХН-ийн анхдугаар их хурлын илтгэл)  
Илтгэгч Д.Ганболд

1990 оноос Монголд ардчилалын үйл явц өрнөснөөс хойш ес дэх жилийн нүүрийг үзэж буй өнөө үе нь хүн төрөлхтөн хөгжил дэвшлийнхээ цоо шинэ эрин үе болох гуравдах мянган жилийн босгыг алхан орох шинэ эрин үетэй байгаа онцлогтой билээ. Ийм түүхэн үед монголчууд бид өмнө хийж бүтээсэн зүйлийнхээ бүх сайн болон муу тал, болон оноог нь эрүүл саруул ухаанаар оновчтой нэгтгэн дүгнэж, улс орныхоо хөгжлийн цаашдын ирээдүйд чин санаа тавьж, түүний төлөө бүх хүч оюун ухаанаа төвлөрүүлэн ажиллах түүхэн хариуцлага тулгарч байгааг МХХН-ийн ухамсарлаж, өөрийн үзэл баримтлалаа эх орон нэгт монголчууддаа үнэн зөвөөр илэрхийлэх цаг хугацаа болсон тус намыг үүсгэн санаачлагчид зүй ёсоор үзэв.

Нэг. Ардчилал ба хүний эрх

1. Ардчилал ба өнөөгийн Монголын нийгэм

1990 оноос эхэлсэн ардчилалын үр шимээр өнөөдрийн монголын нийгэмд иргэд нь хувиараа аж ахуй эрхлэх, бүтээлч ажил хөгжүүлэх, хувь хүн амьдралын боломжоо дээшлүүлэх, эрх чөлөөгөө эдлэх гэх мэт аерэг нааштай үзэгдлүүд байгааг МХХН зүй ёсоор анхаарч ач холбогдлыг нь үнэлэхийн зэрэгцээ нийгмийн амьдралын бүх хүрээг ардчилах үйл явц үүнийнхтэй нь харьцуулбал эрч хүч, далайц нь саарч байгаад сэтгэл зовнир байгаагаа ч илэрхийлэх ёстой хэмээн үзэж байна. Шинэ үндсэн хуулинд "... хүмүүнлэг ардчилсан нийгмийг ..." Монголд байгуулахыг эрхэм зорилго хэмээн үзэж байгааг илэрхийлсэн. Гэтэл өнөөдөр Монголын нийгмийн хөгжлийн ойрын болон алс ирээдүйг тусгасан нэгдсэн цэгцтэй шинжлэх үзэл баримтлал боловсруулаагүй байгаа нь улс орны цаашдын хувь заяаг тодорхойлох явдлыг туйлын төвөгтэй болгож байна. Өнөөдөр нэгэнт бүрэлдсэн нийгмийн ёс зүйн орчинг нарийвчлан авч үзвэл нийгмийн эсрэг буюу шударга бус үйлдлийн хэмжээ улам багасч, сөрөг буюу шударга бус зүйлийн хэмжээ эрс өсч эрүүгийн шинжтэй орчин болон хувирч байна. Ийм үйлдлийнх нь нийгмийг гажуудалд (деформаци) оруулахаас гадна нийгмийн аюулгүй байдалд шууд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс байгааг эргэсэн явдлын шалтгааныг зөвхөн нэг эхлэлээр биш, хэд хэдэн янзын учир шалтгаанаар тайлбарлах нь зөв байх хэрэг бөгөөд үүнд МХХН ул суурьтай хандаж өөрийн байр сууриа илэрхийлэх явдлыг чухал хэмээн үзэж байна. Монгол орныг ардчилалын замаар хөгжүүлэх гэсэн нэг зорилготой мөртлөө хоёр өөр аргатай хэмээн 10 дахь жилдээ өөрсөдөө хоорондоо өрсөлдөж буй МАХН болон Ардчилсан холбоо эвслийн тэмцэл эхэн үедээ нийт улс орны эрх ашгийн хамгийн их хэсгийг эзэлсэн лоозонгоос гараагаа авч хүн амын дийлэнх хэсгийг хэт улс төржүүлж, сонгууль явагдах бүрд өөрсдийгөө ардчилалын эрх зөв үзэл зөвлөлийнхөө хэмээн жүжиглэж, уул овоо шиг их зүйлийг ард түмэнд амлаж олон түмний улс төрийн эрхийг хуурч байгааг бий болгох ердийн хэрэгсэл болгон ашиглаж, үүгээрээ ядуу ард түмнийхээ нүүрэн дээр хоорондоо тансаглан амлаж байгааг харвал доромжлохгүй байна гэж хэн ч хэлэхгүй байх аа.

Улс орны дийлэнх хэсгийг хэт улс төржүүлснээр нийгэмд тогтворгүй эдийн засгийн болон нийгмийн сэтгэл зүйн орчин бий болгож өгснөөр энэ нь өмч хувьчлалыг хотод ч хөдөөд ч гарцаагүй хуудуутай явуулах шударга бус эхлэл болсныг илэрхийлж байна. Өнөөдөр олон үйл явц бэлхэнээ нотлон харуулсаар байна. Хүн амын дийлэнхийг хэт улс төржүүлснээр ардчилалын үзэл баримтлал түүний төлөө гэхээсээ хувийн ашиг сонирхолоо улс төрөөр халхалсан цөөн биш хүмүүс ардчилалын далбаан дор байр сууриа тушаал эзэлж ардчилалын өнгө зүсийг алдагдуулж түүнийг шударга бус замаар бизнес хийх хамгийн дөт арга зам гэж тооцож энэ зохисгүй үзэгдэл цаашид олон хувилбараар бусад намуудад ДОХ өвчин мэт тарсан явдал засаг төрийн үйл ажиллагааг тушаалтнуудын дунд хүртэл эрүүгийн орчин түгэхэд хүргэсэн гэж МХХНам үзэж байна. Үүнийг ямар ч шалтгаанаар явагдаж байлаа гэсэн энгийнээр нотлох болсон үзэгдэл бол засаг төрийн өндөр албан тушаалтны төдийгүй төрийн хэмжээний эрх мэдлийг атгасан хурган дарга нарын авилгал юм. Нийгмийн энэ сөрөг үзэгдэл цаашид өргөжин тархвал нийгмийн эдийн засгийг сөргөхгүй болтол нь унагаж улс төрийн тогтворгүй байдал бий болгож үндэсний аюулгүй байдалд шууд аюул занал гаднаас учирах биш харин дотоодод үүсч болохыг манай нам олон түмэндээ хэлэх нь зөв гэж үзэж байна.

Улс орны амын дунд сонгуулийн ямар нэг компани ажлын үеэр улс төржих явдал байхыг ердөө ч үгүйсгээгүй. Гэхдээ улс төрийн өнөөдөр үчир ч бий хэмжээ ч бий. Ер нь бид цөмөөрөө улс төрч болохгүй, зарим хүмүүст улс төр зохихгүй гэдэг нь хэн ч үгүйсгээгүй ойлгомжтой. Улс төр гэдэг нь явцуу утгаараа жирийн л байдаг олон л мэргэжлүүдийн нэг. Өнөөдөр улс төрийн хөгжлийгээр улс төрийн намуудгүйгээр улс орныхоо амьдралыг сайн сайхан авч яваа улс орон дэлхийд байдаг гэдгийг үгүйсгээгүй байхад илүүдэхгүй биз ээ. Монголчуудад хэт улс төржихөөс илүү чухал юм өнөөдөр байгаа гэдэгт бид итгэдэг. Энэ бол ардчилал илүүдэхгүй байхад доройтлоос гаргах монгол хүний сэтгэлийн агуу их тэнхээн дээр тулгуурласан тогтвортой өсөн дэвшлийн амьдралаа доройтлоос гаргах монгол хүний сэтгэлийн агуу их тэнхээн дээр тулгуурласан тогтвортой өсөн дэвшлийн амьдрал байдаг амьдралын хэвийн орчмыг бий болгох үзэл санаа юм. Монголчууд бид энэ уудам нутаг дээр 2 сая гаруйхан хүн ам бүх хүмүүсээ амьдралын хангамжтай авч явах их хувь тавилан бидний өмнө бодитой оршин байгаа гэдэгт бид итгэнэ. Ардчилалын сонгодог онолын үүднээс авч үзвэл аливаа нийгэм хөгжин дэмжих тэмүүлэлтэй бөгөөд улс төрийн хөгжлийн үр шимийг хүн бүхэн ижил тэгш хэмжээгээр хүртэх ёстой атал өнөөгийн цогцлуулан барьсан монголын улс төрийн зөвхөн цөөн тооны эрх мэдэлтэн ардчилалын үр шимийг хүртэж байгаа явдлыг өрнөдөд очиж дамжаанд сууж ирээд өнөөдөр дээшлүүлсэн "үндэсний онолчид" маань яхир хатуу өрсөлдөөнт зах зээлийн харилцаанд шилжих өнөө үед улс төрийн үзэгдэл гэж ярьж байгаа нь олон нийтийн бухимдлыг төрүүлэх нэг шалтгаан болж байна. Өрнөдийн бодит байдал, улс төрийн онол олон зуун жилийн тогтвортой суурьтай хөгжиж ирсэн. Тэднээс сурах юм байлгүй яахав. Юуны өмнө онолыг

хуулбарлахаасаа өмнө төр засагаа төр засаг шиг болгож, нурсан амьдралаа өөд нь татах үүдийг ашигтай хамээн үзээд, бүх юм цэгцэрсэн хойно янз бүрийн онол ярьж суухыг үгүйсгээд яах билээ. Өнөөдөр манай нийт хүн амын 1/3 нь нийслэлдээ, үлдсэн хэсгийн мөн 1/3 нь 21 аймгийн төв болон суурин газруудад, хүн амын үлдэж байгаа хэсэг нь нүүдлийн маягаар уудам газар нутагтаа амьдарч буй бөгөөд нийт хүн амын 67,4 хувь нь 30 хүртэл насны залуучууд байгаагаас үзвэл манай орныг залуучуудын орон гэж нэрлэдэг. Манай хүний капиталын олзворлодог 20 орны тоонд, нэг хүнд ноогдох олзворлогдсон алтныхаа хэмжээгээр айргийн тавд багтдаг гэдгийг иш үндэс болговол монголын эдийн засаг доройтлоо гэж хэлбэл хэн ч үнэмшмээргүй. Гэтэл монголын нийгэм бүхэлдээ гажуудал олж, нийгмийг хөгжүүлэгч субъект болох хүний капитал бүх талаар доройтож, түүний шалгуур болсон хоол хүнсний хангамж, нийгмийн эрүүл мэндийн халамж, бүх төрлийн үйлчилгээ багасан, өвчлөлт нас баралтын түвшин ихсэж, завсарданаас болж багасаж, гудамжны буюу траншейний гэгдэх хүүхдийн тоо өсч, байгаль орчин бохирдож, хот суурингуудад хүн ам хэт бөөгнөрч, бэлчээрийн даад муудаж байгаа гэх мэт урьд өмнө дуудлаагүй гэж сөрөг үзэгдлүүд гарсаар байгаагийн гол шалтгаан нь өнгөрсөн социалист, коммунист тогтолцооны гажгаас гэхээсээ илүү өнөөгийн төр засгийн улс төр, эдийн засгийн удирдлагын харалган бодлогоос болж байгаа гэж МХХН үзэж байна.

Макро эдийн засгийн хатуу бодлого, амьдралтай зөрчилдсөн макро түвшингийн санхүүгийн хямралаас болж ядуу айм өрхийн тоо өсч, тэжээл багатай хүнсний зүйл тогтмол хэрэглэснээс болж насанд хүрэгчдийн 14 хувь бодит жиндээ хүрэхгүй, долоон хувь нь тураалтай байгаа нь зарим тохиолдолд "идэх хоолтой байх ёстой" гэсэн хүний үндсэн ирм зөрчилдөж ирсний улмаас 1990-1995 онуудад л гэхэд насанд хүрсэн 20-64 насны эрэгтэй мянган хүнд 599, мөн насны өвчнөөс болж нас барсан гэсэн статистикийн баримтууд байгаа нь бидний сэтгэлийг сарт хийлгэхгүй байхын аргагүй. Монголчууд бид хүнээ хамгаалдаггүй ямар нийгэм цогцлон байгуулж байна вэ? Нийгмийн дотор ядуурал газар авч үүний улмаас ядуу хүмүүст нийгмийн амьдралын олон арга хэмжээнд идэвхгүй оролцох хандлага давамгайлж, нийгмийн "гадуурхагдах" болж байна. Монголд нийгмийн гишүүдийнхээ тэн хагасыг "нийгмийн гадуурхалын" хүрээнд орхисон хүнийг үл тоомсорлосон, цөөн тооны хэт баяжсан хүмүүсийн "олонхийн эсрэг хүйтэн тогтолцоот" нийгмийн үндэс суурь тавигдсан юм биш биз дээ. Өнөөдөр сургуулиас завсардсан хүүхдүүд "нийгмээсээ гадуурхадсан" хүмүүсийн хоёр дахь үеийг төлөөлж байна гэхэд хилсдэхгүй. Эд нар өсөж өндийх үед нийгмийн ялгаа улам газар авч, амьдралын бололцоо зүйн түвшинд хүртэл өсөж магадгүй гэдгийг бодоход үгүйсгэх аргагүй. Үүнтэй нэгэн зэрэг настай хүмүүс ертөнцийн мөнх бусыг үзүүлж, цурт шинэ үе төрж гарахын цагт дээрх ялгарал улам тод болно гэдэг нь монголоо гэсэн хүн бүрийн сэтгэлийн түгшээсэн асуудал болж хувирч болохыг үгүйсгэхгүй юм.

2. Монголын хөдөөгийн байдал ба монгол хүний нийгмийн зарим асуудлууд

Монголын хөдөө бол Ази тивийн төв хэсэгт оршиж, өргөн уудам газар нутгийг эзэлдэг бөгөөд хүн амын суурьшилт нь сийрэг. Өөрөөр хэлбэл мянган га-д 15 хүн ноогддог. Дэд бүтэц сул, зах зээлийн төвүүдээс алслагдсан зам харилцаа, холбоо, тээврийн зардал өндөр гэх мэтийн олон бэрхшээл хөдөөгийн ард түмний материаллаг амьдралын түвшинг хязгаарлаж, эрүүл мэнд боловсролын үйлчилгээнд сөрөг нөлөө үзүүлж ядуурлын хэмжээг нэмэгдүүлсээр байна. Албан ёсны өр сурвалжаас үзвэл 1996 онд ядуучуудын тоо улсын хэмжээнд 452405 үүнээс хотод 229450 хөдөөд 222955 байгаа нь хөдөөгийнхний амьдрал суурин газар бараадсан илүү ахуй үйлчилгээтэй хотынхтой тоогоор ойролцоо боловч чанараар доогуур гэдэг нь илэрхий. Нийт нэг ядуучуудын 41% нь аймгийн төвд, 23% нь сумын төвд, 12% нь Улаанбаатар амьдардаг гэсэн тооцоо бий. Хөдөөгийн ядуучууд ихэвчлэн нас залуу, бага ангийн боловсролтой байгаа нь тэдний амьдралын түвшин доогуур байдагтай шууд холбоотой. Аймгуудын төвд ажилгүйдэл ядуурал хамгийн их байна. Хөдөөгийн олон өрх айл амьдралаа залгуулахын тулд хувинараа аж ахуй эрхлэх оролдлого хийсэн боловч санхүү менежментийн дутмаг байдлаас болж онцгой амжилтад хүрээгүй байсаар байна. Сүүлийн жилүүдэд харьцангуй өнцөг өвөд болж байгаагийн ачаар малын тоо толгойг нэмэгдүүлэхэд таатай нөхцөл болж байгаа хэдий ч мал аж ахуйн салбарын байдал тааруу зэрэг нь нэг л өдөр өвгүй загнаж мэдэх цаг агаарын урьдаас мэдрэх боломжгүй гэнэтийн үзэгдэл түүнд хангалтгүй бэлтгэдэг байдал зэрэг олон асуудлууд зөвхөн мал аж ахуйн төдийгүй хөдөөгийн хүн амын хүнсний хангамжийн баталгааг эргэлзээтэй болгож байна. Аймгуудын эдийн засгийн дэмжих бодлогыг гол төлөв мал аж ахуйн амжилттай хөгжиж байгаа ч бусад арьс шир, мах, хивс, ноос, эсгий болон сүүн бүтээгдэхүүний үйлдвэрүүд ахицтай дэмжигдэхгүй байна. Эрчим хүчний гачаалаас болж хөдөөгийн үйлдвэрүүд зогсолтын байдалд орж тухайн бус нутгийн санхүүгийн нөөц, санхүүгийн үйлчилгээ хүрэлцээ муутай байх явдал ердийн үзэгдэл болжээ. Эрүүл мэндийн үйлдвэр хямрал хөдөө орон нутагт үргэлжилж хөдөөгийн хүний эрүүл мэндийн ерөнхий түвшин доройтох хандлага ажиглагдаж байна. Тухайлбал хөдөө орон нутагт эхийн эндэгдэл хотынхоос 2 дахин өндөр төрөлт буурч байгаагаас гадна эхчүүдийн төрөхөөсөө 2 долоо хоногийн өмнө ирж амарждаг, төрөхийн өмнөх амаржих газруудын тэн хагасыг хаасан бөгөөд тургын тусламжийн үйлчилгээ авахын тулд зарим нутагт 50-100км зам туулах, үр хөндөлт баталгаагүй орчинд явагддаг, голны бус нутагт цус ойртолт ихсэж төрсөн хүүхдийн амьдрах чадвар сул доройн улмаас төрөлтийн дараа эндэх аль өсөөд амьдарсан ч ухааны хомсдолтой байж сэтгэцийн гажигтай болж өсөх зэрэг олон баримт үүнийг нотолж байна. Хөдөөгийн хүний эрүүл мэндэд хортойгоор нөдлөөлж байгаа нэг хүчин зүйл бол хүнсний гол бүтээгдэхүүнүүдийн ихэнхийг гаднадаас авч байгаагийн зарим нь хэрэглэх хугацаа хэтэрсэн бүтээгдэхүүнийг наймаачид хямд үнээр оруулж ирээд өчүүхэн шийгийн төлөө монгол хүнийхээ бие эрхтний эрүүл мэндээр дамжуулан туршилт хийж байгаа явдал юм. Эсрэг сурталчилгаа хотод алдаг оног, хөдөөгийн хүн амд хэвлэл мэдээлэл бараг хүрдэггүйн улмаас эрүүл мэндээрээ хохирох явдал олонтой гарсаар байна. Хятад улсаас хууль зөрчин оруулж ирсэн 17 чингэлэг спиртийн тэн хагас нь хөдөө орон нутагт шингэн зарим нь агуулахад худалдагдахаар эзхээстэй байдаг гэдгийг олон хүн мэднэ. Энэ бүхнийг хөдөөгийн монгол хүн өөрийнхөө үнэт капиталын гол нэг хэсэг болсон элэг, тархиараа мэдэж хохирч явна гэж бодоход харамсаад барахгүй бөгөөд архи тамхныг эсрэг сурталчилгааг эрүүл мэндийн байгууллагууд дагнан авч үнэн сэтгэлээсээ итгэл үнэмшилтэй хариуцлагатай хийхгүй ажил байх ёстой мэт өөрсөдөл ойлголт амь бөхтэй оршоор байна.

Хөдөөгийн монгол хүн генийн хувьд эрүүл саруул байх боломжгүй болж цаашдаа монгол үндэстэн геноцидийн аргаар тулах бодит аюул нүүрлэж байна. Хөдөөгийн монгол хүний нийгмийн асуудлын хүрээнд санаа зовж буй бас нэг асуудал бол хөдөөгийн эмэгтэйчүүдийн боловсролын түвшин доогуур байгаа явдал бөгөөд энэ нь тэдний амьдралд янз бүрийн сөрөг нөлөө үзүүлдэг. Боловсрол тааруу учраас ахуй амьдралын олон чухал мэдээллийн гадна тэд үлддэг. Хөдөөд өрх толгойлох эмэгтэйчүүдийн тоо өсөх хандлагатай болж тэд ажлын хүчний дутагдлаас болж ихэвчлэн төрөл багатай, цөөн тооны мал сүрэгтэй байдаг тул байгаль цаг уурын болон бусад гэнэтийн нөлөөлөлд өртөмтгий байдаг. Энэ бүх асуудлаар хөдөө орон нутаг дахь төрийн бус олон нийтийн байгууллагууд ажил зохиож байгаа боловч санхүүгийн гачаалаас болж нааштай үр дүнд хүрэхгүй байна. Эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоо тааруу бөгөөд түүний тод жишээ нь одоогоор аймгийн засаг даргаар нэг ч эмэгтэй сонгогдоогүй явдал юм. Сүүлийн жилүүдэд хөдөөгийн хүн амын, ялангуяа малчдын хүүхдүүдийн сургалттай холбогдсон өрхийн шууд бус зардал нэмэгдэж байгаа нь олон хүүхдүүдтэй айлд хүндээр тусахаас гадна мал хувьчлалын үед өрхийн малын тоо өссөнөөс болж хөвгүүд илүү сургууль завсардахын хамт сумын төвөөс алс нутагтаа мал малчид хүүхдээ дотуур байранд суралцуулах эсэхээ өөрсдөө шийдэж байгаа зэргийн улмаас сургууль завсардалт ба сургуульд хамрагдаагүй байдал их болж байна. Энэ байдлын сөрөг үр дагавар ойрын 70 жилийн дотор мэдрэгдэх бөгөөд сургууль завсардсан хүүхэд уншиж бичихээ мартахагүй юм гэж бодоход 15-аас дээш насны хүмүүсийн бичиг үгсийн

ийгмийн  
тогдос  
спорто  
ранд 5  
ачлалы  
нуульд  
вал авч  
ноон жи  
илжилт  
шилжилт  
шилүүл:  
айлхай  
нийн с:  
хүүхдээ  
н болс  
нууле  
нар нь  
он бай  
н мэд  
н байн  
Ардчи  
нх болс  
нх сон  
нхх бо  
нуульс  
нхнр эр  
удал и  
нар хо  
нөөс өд  
олцоо  
нн. Сөр  
драл би  
нхсон б  
нн нь 1  
Н  
Х  
шил то.  
Т  
М  
нээ. Ул  
нийг аг  
мэдлээ  
нх хий  
нх хүч  
ХН нь  
нн асу  
нд гар  
норгүй  
нх, хөг  
нн улс  
үүнд тг  
нээд ал  
нхж бг  
нхж зэ  
Д;  
ийн жи  
нновч  
н-рмад



ийн үйлийг хэрэгжүүлэхдээ амлалт өгөх нь чухал биш.  
ийн гол нь бат итгэлтэйгээр хийж эхлэх явдал чухал юм.

Анхаарал тавьсан Та бүхэнд баярлалаа.

## Улс төрийн харилцаа, нийгмийн байгуулалтын талаар

илтгэгч Д.Цэцэгмаа ( ТИС багш )

ийн хөгжилд голлох үүрэг гүйцэтгэдэг нийгмийн амьдралын хүрээ бол улс төрийн хүрээ юм. Нийгмийн, улс төрийн  
ийн тухайн улсын нөхцөлд тохирсон зохион байгуулалттай, жигд ажиллагаатай байвал нийгмийн амьдрал  
ийн байж тухайн улс орон дэвшин дээшилж байдаг билээ.

1990 оны хувьсгалаас хойшхи Монгол улсын хөгжлийг эргэн харвал өөрчлөлт шинэчлэлт эн тэргүүнд улс төрийн  
ийн илгэдсэн билээ. Улс төрийн эрх чөлөөгөөр цагласан ард түмэн тэрхүү өөрчлөлтийг талархан хүлээн авсан бөгөөд  
ийн хөгжүүлэх нь улс орны цаашдын хөгжлийн зайлшгүй нөхцөл юм гэдгийг ойлгосны үрээр 1992 оны УИХ-ын  
ийн ардчилсан хүчнийхэн ердөө л 6 суудал авч байсан бол 1996 оны сонгуулиар УИХ-ын 50 суудал буюу 65 хувийн  
ийн Засгийн байгуулах эрх олж авсан билээ. Үүнээс харахад монголын ард түмний улс төрийн ухамсар ийнхүү  
ийн жилийн дотор эрс өөрчлөгдөж ардчлалын замыг эргэлт буцалтгүй сонгож, хуучин нийгмээс шинэ нийгэмд шилжих  
ийн ялтийг тууштай хийхийг хүссэн байна. Ард түмэн ардчилсан хүчнийхэнд төрийн эрхийг олгохдоо нийгмийн  
ийн ялтийг түргэсгэснээр богино хугацааны дотор нийгмийн амьдралыг тогтворжуулж, хүмүүсийн амьдрал ахуйг  
ийн үүлэх таатай нөхцөл бүрдэнэ гэж найдаж байсан. Гэтэл өнгөрсөн хоёр жил хагасын дотор ард түмний хүсэн хүлээсэн  
ийн ахан амьдрал бодит байдал болж чадсангүй. Өнөөгийн төр маань нийгмийн удирдах үүргийг гүйцэтгэхээс илүү олон  
ийн санаа сэтгэлээр тоглож, Монголчуудыг бүх нийтээр нь улс төржүүлж байна. Хүмүүс дор бүрнээ амьдрал ахуйгаа  
ийн үлэхээс илүү Засгийн газар, УИХ-ын үйл ажиллагааг сонирхож эрх мэдэлтнүүдийн булхай, зүй бус үйлдлийн тухай  
ийн болсон байна. Төрийн нийгэмд гүйцэтгэх үүргийг авч үзье. Аливаа улсад төр байгаа бол зайлшгүй эдийн засгийн  
ийн суулалт, нийгмийн соёл, Шинжлэх ухаан, экологи, болсвол, үндсэний бодлого боловсруулан хэрэгжүүлж байх ёстой.  
ийн нь алдагдсан эсвэл хэрэгжүүлж чадахгүй байгаагаас ард түмний амьжиргаа өдрөөс өдөрт доройтож, амьдрах орчин  
ийн байгалиа хайр найргүй устгаж, соёл боловсрол, шинжлэх ухаан нь хямралт байдлаас гарч чадахгүй байгааг хүн  
ийн мэдэх билээ. Үүний учир шалтгаан юунд байна вэ . "Ямар учраас төрийн тогтолцооны жигд ажиллагаа алдагдаж,  
ийн байн засаглалын эзэнгүйдэл гарч ирээд байдаг болчихов доо" гэсэн асуултууд шил шилээ даран гарч ирэх нь зүй юм  
ийн ардчилсан хүчнийхэн төрийн эрх мэдлийг авсан цагаасаа эхлэн улс үндсний эрх ашгаас хувийн эрх ашгаа дээгүүр  
ийн болсон амьжиргааг нь дээшлүүлнэ хэмээн сонгогчидтой гэрээ байгуулж, тэдний итгэлийг олж авсан УИХ-ын гишүүд  
ийн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхийн төлөө үйл ажиллагаагаа чиглүүлэхийн оронд эрх мэдлийн төлөө  
ийн болсон. Засаглалын салаа мөчир болсон хууль тогтоогчид засгийн газар хоёр нь хоорондоо зөрчилдөж, өөрсдийн  
ийн суулсан засгийн газраа дараалан унагаж засаглалын хоосон орон зай бий болгосноос гарсан эдийн засаг, нийгмийн үр  
ийн асар эргээд ард түмний нуруун дээр хүнд ачаа болон бууж байна. Засгийн газар, УИХ, Ерөнхийлөгч хоорондоо зохицож  
ийн адал шийдвэрлэх чадвараар сул, мөн УИХ нь хүртэл дортроо хэд хэдэн фракцидхуваагдчихаад зөвшилцөлд хүрэх  
ийн асар комс болж бодит байдал ниймдээ хүрчээ. Судалгаанаас үзэхэд төрийн эрх барьж байгаа улс төрчдөд итгэх итгэл  
ийн төлөө одерт хэлбэрэлтгүй буурсаар байна. 1998 оны 10-р сарын судалгааны дүнг 3-р сарынхтай харьцуулахад улс төрийн  
ийн төлөө сэтгэлд нь нийцдэг гэж судалгаанд хамрагдагсдын 41,9 хувь анх хариулж байсан бол 23,5хувь болтол буурсан  
ийн бил.Сөрөг хүчний үйл ажиллагааны үнэлгээ ч буурсан байна. Мөн Ерөнхийлөгчийн рейтинг 62,2 хувиас 39,8 хувь болж  
ийн буурсан байна. Гэтэл засаглалын сонголт дээр ерөнхийлөгчийн засаглалыг судалгаанд хамрагдагсдын 63,8 хувь нь  
ийн болсон байна.Үүнээс үзэхэд манай улсын өнөөгийн улс төрийн тогтолцооо ард түмний эрх ашгийг илэрхийлж чадахгүй  
ийн байгаа нь илт юм.

Намын доторх фракцуудын ашиг сонирхол хоорондоо зөрөлдөж УИХ-ын үйл ажиллагаа сааталд орж байна.  
Хууль хэлэлцэх дараалал тогтоохдоо аливаа бүлэглэлийн эрх ашигтай холбоотой хуулийг эхэлж хэлэлцдэг  
ийн ажил тогтсон байна.

Төрийн дээд зиндаанд албан тушаалаар наймаа хийж авилгалаар хөөцөлддөг улс төрийн хүчин нэгэнт бий  
ийн ажээ.

Монгол орон өнөөдөр улс төрийн том хүчнүүдийн мөргөлдөөний золиос болж байна гэж хэлэхэд буруудахгүй  
ийн ажээ. Улс төрийн амбици газар авч сонгуулийн үед хоосон амлалтаар ард түмэндээ молиго үмхүүлэн засгийн газрын эрх  
ийн ялтийг аваад сэтгэл амран, улс орны хөгжил, ард түмний амьжиргаа гэхээсээ илүү сонгуулиас сонгуулийн хооронд олсон  
ийн мэдлээ амин хувийн амьдралаа баталгаажуулахад хэрхэн ашиглах вэ гэдэгт толгойгоо гашилган албан тушаалын  
ийн найма хийдэг боллоо гэж ард түмэн хэлэлцэх болсон нь нууц биш юм. Ийнхүү төрийн дамшууралын хариуцлагыг эрх  
ийн ашигч хүчин, сөрөг хүчин хоёул адилхан хүлээх ёстой. Төр барих олон жилийн туршлага хуритлуулсан намын хужвд  
ийн УИХН нь ардчилсан явуулж буй бодлогот эрүүл саруул ухааны үүднээс дүгнэлт өгч, нийт үндсний эрх ашгийн үүднээс  
ийн найма асуудлыг зөвөөр шийдвэрлэхэд нөлөөлөх ёстой атал одоогийн УИХ-ыг тарааж, дахин сонгууль явуулж засгийн  
ийн ялтид гарах цаг хугацаа ойртуулахыг гол зорилгоо болгон тавьж байгаа нь алхам дутамд мэдрэгдэж байна. Улс төрийн  
ийн тогтворгүй байдал нь нийгмийн дэвшлийг саатуулахаас өөр ашиг хонжоо огөхгүй. Монголын нийгэм хямралыг гэтэлэн  
ийн буулж, хөгжил дэвшлийн зам дээр гарахад зайлшгүй шаардагдах нөхцөл бол улс орны тогтвортой байдал юм. Тэгэхлээр  
ийн аливаа улс төрийн хүч асуудлыг шийдвэрлэхдээ үндэстнийхээ эрх ашгийг эрхэмлэн зөвшилцөлд хүрэх арга замыг эн  
ийн үргүүнд тавих нь зүйтэй. Засаглалын комсдол төрийн удирдлагын бүх шатанд газар авч сахилга дэг журмын хэвийн хэм  
ийн эмжээ алдагдсаны улмаас төсвийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулж буйг хэвлэл мэдээллийн хэрэгслээр  
ийн мэдэвлж байгаа ч төсвийн алдагдал өдрөөс одөрт нэмэгдэж, төсвийн байгууллагуудын ажилчдын цалин хөлс, тэтгэвэр,  
ийн тэтгэмж зэрэгн цаг хугацаандаа тавигдаж чадахгүй байгаа тул ард түмний бухимдал улам бүр хуримтлагдсаар байна.

Дээрх байдлаас гарч монгол үндэс угсаагаа хөгжүүлэе гэж бодвол улс төрийн корпоратив харилцаанаас зайлсхийх  
ийн төрийн жинхэнэ түшээг шударга сонголтоор тохоохыг энэ цаг үе биднээс шаардаж байна. 1990 онд зөв үүсгэн санаачласан  
ийн боловч одоо өнгө зүсээ алдаж буй ардчлалыг эргүүлж зөв голдирогт нь оруулах хэрэгтэй байна. Нийгмийн одоогийн  
ийн деформацийг зогсооё гэвэл төрийн зохистой бодлогыг бодит ажил болгох нь зүйтэй юм. Үүнийг хэрэгжүүлэх гол түшиг  
ийн тулгуур нь нэг талаас ард түмний хяналт, нөгөө талаас төрийн үйл ажиллагааны тод байдал билээ.

боловсролын түвшин 2002 он гэхэд 1990 оны өмнөх түвшингээс буурах бөгөөд үүнд хөдөөгийн эрэгтэйчүүд өртөх магадлал өндөр байх болно гэдгийг ч бид бодолцоо эсгөж байна. Өнөөгийн хөдөөд боловсрол олгож буй тогтолцоог эрс шинэчлэхгүй бол олон тосны хагас дутуу боловсролтой хүүхдүүд насанд хүрэгчидийн эгнээнд орно гэсэн үг юм. Хөдөөгийн хөгжлийн нийгмийн даруй шийдвэрлэх ёстой асуудал бол бэлчээрийн даацын тухай асуудал юм. Өнөөдөр нэг малд 2.4 га бэлчээр ноогддог байгаа бөгөөд цаашдаа мал аж ахуй эрчимжихэд энэ нь боломжгүй болох юм. Энэ талаар хавсралт илтгэлд дурьдах учир нь бүхнээс хүлцэл өгчө. Энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь олон чухал асуудлуудын голлоо болно гэдгийг МХХН-ам ухаарч байна.

## Хоёр. Монголын хөдөөг өөрчлөн хөгжүүлэх үзэл баримтлалын асуудлууд

### 1. Хөдөөгийн хөгжлийн стратегийн бодлого

Аливаа нийгмийн хөгжлийг хоёр хэлбэрээр авч үздэг. Эхнийх нь нийгмийг хөгжүүлэх идэвхгүй хэлбэр буюу хөгжингүй ёстой хөгжил, удаахийг нь нийгмийг хөгжүүлэх идэвхтэй хэлбэр буюу хөгжүүлэх ёстой хөгжил гэдэг. Монголын хөдөөд хөгжүүлэх ёстой хэлбэрээр нь хөгжүүлэх цаг нэгэнт болсон бөгөөд энэ "чухал найдвартай ар тал" болсон хөдөөгүйгээр монгол улсын хөгжлийг төсөөлөх нь утгагүй юм. Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд ардчилалын бий болгосон бололцоог олон талаар чадварлаг ашиглах нь зайлшгүй чухал. Эс тэгвээс нийгмийн олон чухал асуудлыг шийдвэрлэхэд хөдөөгийн хүн ам нийгмийн гадуурхлын хүрээнд үлдэх болно. Өнөөдөр монголын нийгмийг хөгжүүлэх асуудлыг зөвхөн гадаадын өөр нөхцөлд бий болж түүндээ үйлчилж чаддаг онолын монголын өөрийн гэсэн онцлогтой нөхцөлд хүчээр "соёлуулах" аргаар хэрэгжүүлэх үү? Аль эсвэл макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг өөрийн орны нэгэнт бүрдсэн түүхэн тодорхой нөхцөлөөр дамжуулан "шүүж" өөрийн гэсэн хөгжлийн загварыг гаргаж авах уу? гэсэн хоёр замын аль нэгийг сонгох болно? Мэдээжийн хэрэг, онол бол онол, амьдрал бол түүнээс өөр гэдэг нь хүн бүхэнд ойлгомжтой. Амьдрал дээр бүх юмыг үнэ үргэлж онолоор хийхгүй. Заримдаа үйлийн талын ашигийг зөв билгээрээ дагахаас аргагүй үе ч байдаг. Чухамдаа монголын нийгмийг гажуудлаас гаргах өвөө үед онол ярьж суух цаг одоо биш, үйл ажиллагааны талыг голлон нийгмийн эгнээтэй асуудлуудыг шуурхай шийдвэрлэхэд МХХН онцгой анхаарч байна. Монголын нийгмийг бүхэлд нь хамарсан хямралын гаргах явдал тус намын стратегийн гол зорилт бөгөөд үүнийг хэрэгжүүлэхэд нэн тэргүүнд шийдвэрлэх гол асуудал бол нийгмийн амьдралыг бүхэлд нь хамарч эхлээд буй ядуурал юм. Ядуурлын гол золиос хөдөөгийн монгол хүн бөгөөд түүнийг ядуурлаас ангижруулахын тулд эрүүл мэнд, боловсролын аль алиныг ядуурлаас салгаж өгдөг хэрэгсэл мэтээр ойлгох алдаатай бөгөөд энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд юуны өмнө амьдралын бодит орчинг нь бүрэлдүүлэхэд МХХН анхаарч ёстой гэж үзэж байна. Ийм учраас монголын нийгмийг бүхэлд нь хамарсан ядуурлыг бууруулахын тулд хөдөөгийн монголын хүний нийгмийн асуудлыг гол цөмөө болгосон хүн төвтэй хөгжлийн үзэл баримтлал манай намын үйл ажиллагааны эхний бөгөөд эцсийн зорилго гэж зүй ёсоор ойлгож байна. Дээрх гол зорилтоо хэрэгжүүлэхдээ хөдөөгийн ядуучуудын амьдралыг бодит байдал, тодорхой нөхцөл байдлыг яв цав тусгасан нэгдсэн бодлогыг боловсруулах нь зайлшгүй. Үүнийг хэрэгжүүлэх өюуны гол потенциал бол өнгөрсөн хугацаанд төдийгүй одоо бэлтгэгдэж буй манай нийгмийн оюуны үнэт баялаг болно. Өндөр чанартай боловсролыг эзэмшсэн ХАА-н шинжлэх ухааны эрдэмтэн мэргэд, мэргэжилтэй боловсон хүчин байх ёстой гэж манай нам үзэж байна. Үүний зэрэгцээ хөдөөгийн нийгмийн асуудлын бэрхшээлийг даван туулахад бусад хүн шинжлэх ухааны, ер нь монголын бодит хөгжил дэвшлийн төлөө санаа тавьж зүтгэх бизнесменүүд, бүх хүмүүстэй хамтран ажиллахад манай нам бэлэн байгаагаа илэрхийлнэ. Мөн монголын хөдөөг хөгжүүлэх ерөнхий үзэл баримтлал боловсруулахад гадаадын зохих мэргэжилтэй хүмүүсийг татан оролцуулах боломжийг бид судалж үзэх болно. Монголын хөдөөгийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд өөрөө өөрийгөө дотоодлоо хоршиж амьдрах замаар тэтгэх аргын эр холбогдолын зэрэгцээ монголын хөдөөд гадаадаас доривтой хөрөнгө оруулалт хийхийн чухлыг ч МХХН ухаарч байна. Хөдөөд ядуурлыг бууруулахад гол саад тогтвор учруулж байгаа зүйл бол өдрөөс өдөрт хоёр тийш туйлширч байгаа нийгмийн гишүүдийн амьжиргааны тэгш бус байдал юм. Хэрэв монголчууд бид харсаар байгаад энэ асуудлыг анхаарлынхаа төвөөс гаргавал европын түүхэнд капиталын анхны хуримтлал цус, хөлс, балчиг дунд явагдсан шиг тэгш байдал нийгмийн дотор бий болж монголын нийгэмд хэт баян, хэт ядуу гэсэн хоёр хэсгээс тогтсон хөгжих дэмжлэг бололцоо нь хаагдсан, ирээдүйгүй бөгөөд өөрөө өөрийгөө хүнийгсэсэн "нийгмийн хүйтэн харилцаатай" тогтвортой тогтолцоо болж хувирна. Бид үр хүүхэд, хойч үе тийм нийгэмд орхиод ертөнцийн мөнх бусыг санаа амарлингүй үгүйсгэх эрхгүй гэж бодож байгаатай та бүхэн бодол санаа нийлнэ гэдэгт МХХН та бүхэнд итгэж байна. Хүн төрөлхтөн хөгжлээ дэвшлийн гурав дахь мянган жилийн зах руу орж байхад монголчууд бидэнд ийм сонголт хийх эрх байхгүй.

### 2. Монголын хөдөөг хөгжүүлэх бодлогын тактикийн зарим асуудлууд

Монголын хөдөөг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн эрх мэдлийн төвлөрлийг аймаг сумын хэмжээнд хүртэл сааруулах үйл явцыг богино хугацаанд тууштай хэрэгжүүлэх нь чухал гэж МХХН үзэж байна. Орон нутагт аймгийн даргад эрх мэдэл төвлөрсөн хэвээр байгаа нь орон нутгийн засаг захиргааны доод шатны байгууллагуудын хүч чадлыг сулруулж, тэд хүн амын санаа бодлыг тэр болгон бүрэн дамжуулж чадахгүйн зэрэгцээ УИХ, засгийн газар болон нутгийн эрх баригчдийн үйл ажиллагаа, гаргаж байгаа шийдвэр олон түмний нүднээс далд хийгдэх, энэ талаар мэдээлэл олж авах боломж туйлын хомс байгаагийн улмаас төрийн дээд тушаалтны дунд улсын хөрөнгө, монгийн амин ашиг ашгаа нэмэгдүүлэхэд ашиглах, авилгалд өртөх явдал үнэхээр жигшмээр өргөн ил цар хүрээтэй болж байгааг олон түмний харахгүй, мэдэхгүй өнгөрөх аргагүй бөгөөд ийм албан тушаалтны үйл ажиллагааны талаарх мэдээллээр нийгмийн хангагдаж байх тийм системийг сонгогч олон түмэн УИХ болон засгийн газарт шахалт үзүүлэх замаар бий болгох аргаар байдалыг таслан зогсоож болох юм. Ес суртахууны хувьд алдаа гаргасан УИХ-н гишүүнийг сонгосон тойргийн сонгогч УИХ-с нэрийг нь татах, энэ байдал УИХ-д газар авбал УИХ-ыг тараах хүртэл санал гаргах эрхийг сонгогчид үйлдэх хуулиар олгогдсон улс төрийн эрхийнхээ дагуу эдлэх ёстой гэж МХХН үзэж байна. Төв болон орон нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа, тэдгээрийн дотоод санхүүгийн менежмент, хөрөнгө ашиглалтын алдааг дороос нь хянах олон түмний хявалтын системийг бий болгох нь өнөөдөр чухлаар шаардагдаж байна. Монголын нийгмийн хөдөөгийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд эрүүл мэнд, боловсролын санхүүжилт, нийгмийн халамж, татвар өнөөгийн тогтолцоог дахин эргэж харж боловсронгуй болгох явдал ч зүй ёсоор гарч байна. Монголын нийгмийн хөгжлийн өнөөгийн эдрээтэй үед улс орныг хямралаас гаргахын тулд төв болон орон нутгийн засаг захиргааны зүгээс үндсэн үйлдвэрлэлийг сэргээхийн тулд явуулж буй арга хэмжээнүүд нь тэр болгон үр ашигтай байж олон түмний дэмжлэгийг чадахгүй байхын зэрэгцээ зарим явуулсан арга хэмжээ нь эхнийхтэйгээ зөрчилдөх, улмаар нийгмийн ядуурлыг багасгах биш, харин ч нэмэгдүүлэх хандлага гарч байгаа нь төрийн түшээвүүдийн ажлын хариуцлага, сахилга бат суларч холбоотой. Ядуучуудын эсрэг чиглэсэн ямарваа арга хэмжээг тухай бүр таслан зогсоож байдаг тийм төр засгийн өнөөдөр үгүйлэгдэж байна.

Хариуцлага, чанд сахилга бат, өндөр зохион байгуулалт, үндэсний эвлэрэл дээр тулгуурласан эв нэгдэл бол монголын нийгмийг хямралаас гаргахад чухал хөшүүргүүд байх ёстой гэж МХХН үзэж байна. Энэ мэтээр хөдөөгийн нийгмийн шийдвэрлэвэл зохих олон чухал асуудлын талаарх санаа бодол олон байх бөгөөд асуудлын жагсаалтыг нэрлэхдээ биш, хамгийн гол нь ямар тулгуур асуудлаас эхлэх вэ гэдэг нь чухал юм.

МХХН энэ талаар өөрийн гэсэн үзэл баримтлалтай бөгөөд энэ нь хөдөөгийн монгол хүний чадавхийг бүх талаар хөгжүүлэх үр шимийг нь өөрт нь бодитойгоор амсуулах нь чухал гэсэн санаа юм. Хүн тодорхой хэмжээний чадавхийг хөгшин хүн юм бүтээдэг. Хүний чадавхийг бий болгохын тулд нийгмийн олон талт арга хэмжээнд чөлөөтэй оролцох, мөшигч үүрэг санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, иргэн бүр чөлөөтэй сонголт хийх эрхээ бодитойгоор эдлэхийн тулд иргэний зориг сэтгэлээ илэрхийлж чадах тийм нийгмийн орчинг бүрэлдүүлэх явдал хамгаас чухал юм.

# Хөдөөгийн нийгмийн асуудал ба нийгмийн хамгааллын байдал.

Илтгэгч. С. Дивангар. ХААИС- н багш

## 1. Эдийн засгийн талаар.

Эдийн засгийн төр засгаас баримталж байгаа эдийн засгийн бодлого, явуулж байгаа үйл ажиллагаа нь нийт хүн амын 50 орчим хувийг эзэлдэг малчин тариаланчид буюу хөдөөгийнхний амьжиргаанд бодитой тусаж чадахгүй байна. Үүний улмаас хөдөөгийнхний амьдрал сүүлийн жилүүдэд ихээхэн доройтжээ. Манай улсад 183636 малчин өрх байдаг. Тэдний орлогын 70 хувийг эх үүсвэр нь мах, сүү, ноос, үс гэх мэт хэдхэн төрлөөс бүрддэг бөгөөд, орхийн оролгын 43, 9 хувийг мал болон, мах үйлдвэрийн орлого эзэлдэг байна. Харин тариаланчдын орлогын үндсэн эх үүсвэр нь үр тариа, төмс хүнсний ногоо юм. Малчид тариаланчид эдгээр бүтээгдэхүүнүүдээ зах зээлийн боломжтой дээд ханшаар борлуулах, эдийн засгийн зорилго, орчин бүрдээгүй төдийгүй бэлэн мөнгөөр арилжих боломж бүр ч хязгаарлагдмал байгаа нь харагдаж байна. Өмч эзэмшлээр ноогдсон малаа авч, жалга бүхэнд ганц нэг өрхөөрөө тарсан малчид маань өөрсдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ төвлөрсөн зах зээлд хүргэх ямар ч нөхцөл боломж байхгүй бөгөөд зөвхөн ганцагын наймаачин, ченж ажилчдын хувиар хувиар баруун орнуудад борлуулах замаар борлуулах ганцхан боломж л байгаа юм. Үүний улмаас тэд бэлэн мөнгөний хэрэгцээг хангахад хэцүү байдаг. Манай улсын мөнгөний эргэлтийн дөнгөж 9 хувь нь хөдөөд эргэлдэж байгаа гэсэн мэдээ баримттай нотлох буй заа. Хөдөөгийнхөнд хувцас хунар хоол, хүнс, бусад ахуйн хэрэгцээт зүйлс худалдаж авах, татвар төлөх, хөдөөгийн боловсрол эзэмшүүлэх зэргээр бэлэн мөнгөний хэрэгцээ улам бүр ихэссээр байна. Бэлэн мөнгөний асар их хэрэгцээ болон, бага хэмжээний орлого хоёрын ихээхэн зөрөөтэй байдал нь тэднийг зах зээлд татагдан төвийн бүс рүү шилжин зам харилцаа бараадаг бөөгнөрөн байрших үндсэн шалтгаан болж байна. Энэ нөхцөл байдал нь хөдөөг доройтуулах, тэдний үйл ажиллагааг нь дэмжих, төр засгийн бодлого үгүйсгэж байгааг гэрчилж байгаа юм. Малын тоо өндөр өсөж байгаа ганцхан үзүүлэлтээр хөдөөгийн амьдрал сайжирч байна гэж дүгнэх бололцоогүй юм. Мал аж ахуйн бүтээгдэхүүнээрээ хэрэгцээгээр бүрэн хангаж байгаа төргүүний ажиллагаатай мянгад малчид 948 буюу нийт малчин өрхийн тооноос 0,5 хувийг эзэлж байгаа юм. Өнөөдөр хөдөөгийнхөн маань таваарыг таваараар сольдог хэдэн зуун жилийн өмнөх үзүүлэлт эдийн засгийн харилцааны аргаар амьдарч байна гэж хэлж болохоор байна. Хот суурин газрынхан болон хөдөөгийнхний бэлэн мөнгөний эргэлтийн, энэ тэнцвэргүй байдлыг зохистой харьцаанд байлгах төрөөс зориуд төрөөр тодорхой бодлого хэрэгжүүлэх шаардлагатай болжээ. Төр засгийн эрхэм удирдлагууд болон төв суурин газрынхан өөрсөдөө дээд тал дээр зарцуулж, шоу зохион байгуулж, бие биесээ хэд хэдэн саяар ээлжлэн шагнацгааж, үнэтэй машин унаж, хувцас хэрэгцээг өмсөж, гар утас барьцгааж хангалуун амьдарцгааж байхад хөдөөд 70 төгрөгний үнэтэй радионы зайгаа авч байхад бэлэн мөнгөгүй айл өрх заххаас аван байгааг бүх шатны удирдлагууд анхааралдаа авах цаг болсон гэж үзэж байгаа юм. Өнөөдөр 250 гаруй нэгдэл, 50-аад САА, 40-өөд саалийн механикжсан ферм, 500-аад эмчилгээ тэжээлийн цэг, 100-аад мал төллүүлэх бааз, мал бордох цэг талбай байсан нь ихээхэний харилцаанд шилжин өмч хувьчлах үед бараг 100 гаруй үлдэлгүй задран бутарсан байна. Ингэж мал аж ахуйн бүтэц, бүрэлдхүүн, зохион байгуулалт задрахдаа 1960 оны үеийн хувийн ардын аж ахуйтны үеийнхээс ч ухарсан юм. Энэ нь өмч хувьчлалын алдаатай бодлоготой холбоотой бөгөөд тэднийг засах залруулах талаар тодорхой ажил хийгдэхгүй байна. Хөдөөгийнхний өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байгаа байдал болон оюуны хэрэгцээг шаардлагыг нь хангахын тулд хүч хөдөлмөр оюун ухааны хоршилтыг олон янзын хэлбэрээр өндөр дүрэн үндсэн дээр зөв зохион байгуулах замаар эхлэх хэрэгтэй юм. Өнгөрсөн жилүүдэд малчид, тариаланчид маань үйлдвэрлэж хоршин ажиллах ач тусыг зах зээлийн эдийн засгийн утгаар нь үнэлж ойлгожээ. Ийм учраас хоршооллыг тэдний өөрсдийн үүсгэл санаачилгаар байгуулах нөхцөл бололцоо бүрдсэн гэж үздэг болно. Мянга давсан малтай малчид ах дүүс, нутаг уснаараа нийлсэн хот айл цаашид яаж зах зээлд зохицон амьдрах арга ухаанаа олохгүй байна. Тэдэнд мэргэжлийн хүний зөвлөгөө тусламж, төрийн тодорхой бодлого, дэмжлэг өгүүлэгдэж байна. Мал аж ахуйгаас өөр эдийн засгийн гойд салбаргүй манай оронд Мал аж ахуй ноёнлон хөгжих нь гарцаагүй байхад зайлшгүй билээ. Иймд мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн боловсруулдаг жижиг дунд үйлдвэрийн түүхий эдийн засгийн түшиглэн зөв байрлуулж, шинээр байгуулах ажлыг зохион байгуулах, дэмжих хэрэгтэй байна. Монгол малын тооноос шим их биш ч гэсэн экологийн хувьд цэвэр, төгс чанартай нандин бүтээгдэхүүн өгдөг онцлогтой. Монгол малын тооноос шимийн гарц байгалаас 100 хувь хараат байдаг учраас бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэхийн тулд монгол малын тооноос шимийг өгөөжийг дээшлүүлэх асуудал зах зээлийн хуулиар тавигдах нь зайлшгүй юм. Дараачийн шатанд огт дэд бүтэц хөгжөөгүй байдлыг анхаарч урт хугацааны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор тодорхой хугацаанд үе шаттайгаар нийдвэрлэх ажил зохион байгуулах хэрэгтэй болно. Манай улсын хүн амын ялангуяа хот суурин газрын хүн амын өсөн нэмэгдэж буй хэрэгцээг дан ганц бэлчээрийн мал аж ахуйгаас хангах боломжгүй нь мэдээжийн хэрэг. Иймд хөдөөгийн хотуудын дүүрэгт багтаж буй мал аж ахуйн салбарыг зохистой байршуулах, байрын маллагаанд бүрэн зохицсон үндсэн үр ашгтай бага, дунд оврын үйлдвэржсэн мал аж ахуйн цогцолборыг эрхлэх ажлыг төрөөс хөхүүлэн дэмжвээс үндэслэн.

## 2. Соёл боловсрол, эрүүл мэндийн талаар.

Бид хүн төрөлхтний их соёл иргэншлийн эрин үед амьдарч байгаа билээ. Гэвч хөдөө нутгийнхан ахуйн болон соёлын амьдралыг наад захын үйлчилгээг ч хүртээж чадахгүй байна. Зах зээлийн үед хүний амьдралд нэн шаардлагатай үнэн зүйл бодит мэдээлэл байдаг гэж бид үздэг. Мэдээллийн үндсэн эх сурвалж болох сонин хэвлэл ихээхэн хожимдож, хугацаа алдаж очдог. Тиймээс мэдээлэл нь үнэ цэнээ аль хэдийн алдсан байдаг байна. Өнөөгийн байдлаар хөдөөгийн малчид тариаланчид нийгмийн доторхи мэдээллийг явуулын хүний амнаас цуу ярианы хэлбэрээр хүлээн авч байгаа юм. Мэдээллийн бодит үнэнийг ихээхэн гажуудуулдаг энэ хэлбэр өнөөгийн нийгмийн харилцааны бодит шаардлагыг хангаж байхгүй нь мэдээжийн хэрэг.

Хөдөөгийн мэдээлэл авах өргөн боломжтой ганц эх үүсвэр бол радио юм. Гэвч бэлэн мөнгөний хомсдол асар их байдаг учир радио нь радио байтугай түүний зай тэжээл ч авч чадахгүй байгаа тухай дээр тодорхой өгүүлсэн билээ.

Хөдөөд үзвэр үйлчилгээ соёлын арга хэмжээ бараг үгүй болжээ. Манай улсын нийт малчин өрхийн 54,7 хувь нь 16-35 насны залуучууд байгаа юм. Тэдгээр залуус соёлын үйлчилгээ, арга хэмжээг ихээхэн хүсэн хүлээж байгаа нь мэдээжийн хэрэг. Соёл боловсролын хэрэгцээ шаардлагыг нь өчүүхэн төдий ч хангаж чадахгүй байгаа учраас залуучууд төв суурин газруудад тэмүүлэх нь огт буруугүй юм.

Хөдөөд сумуудыг мэргэжилтэй, чадвартай боловсон хүчнээр хангах талаар баримталж байгаа төрийн бодлого алга байна. Хөдөөгийнхний нийгмийн хамгаалал бүрэн орхигдсон учраас мэдлэг боловсролтой, ажиллах чадвартай боловсон хүчин огт очихгүй байна гэж үзэж болно. Үүний улмаас төрийн бодлогыг хэрэгжүүлэх, хөдөөг хөгжүүлэх, хөдөөгийнхнийг байгуулах үүрэг бүхий анхан шатны нэгжийн удирдлагуудын зонхилох хэсэг нь мэдлэг боловсролоороо гологдож хөдөөгийн шаардлагыг хангаж чадахгүйд хүрч байна.

Хөдөөгийн сургуулиудын сургалтын чанар сүүлийн жилүүдэд ихээхэн муудсан байна. Энэ нь багш нарын ажиллах нөхцөл боломж болон сургуулийн материаллаг баазыг дээшлүүлэх талаар төрөөс дорвитой арга хэмжээ авахгүй байгаагаар холбоотой юм. Багш нар цалингаа сардаа багтаж авч чадахгүй байх явдал жирийн үзэгдэл мэт болжээ. Хөдөөгийн сургалт муудсаны үр дүнд нэг шинж нь сургууль завсардалт ихэссэн явдал юм. Сүүлийн жилүүдэд сургууль завсардсан хүүхдүүдийн ихэнх нь хөдөөгийн хүүхдүүд байгаа юм. Хөдөөгийн хүүхдүүдэд сургууль завсардсан олон хүчин зүйлс үндэслэн.



байгаа нь мэдээж. Эдгээрийн дотроос голлох нөлөөлөл үзүүлсэн хүчин зүйлс бол малчид ганц хоёр өрхөөрөө салж тарах бутарсан явдал юм. Хот айлын зохион байгуулалтанд ороогүй айл өрхүүдэд хөдөлмөр хоршилт үгүй болсны улмаас хөдөлмөрлөх хүч байнга дутагдаж байгаа юм. Сургууль завсардсан хөдөөний хүүхдүүдийн ихэнх хувь нь эрэгтэй хүүхэд байгаа нь үүнийг нотлож байгаа юм. Дээрх нөхцөл байдлыг харгалзан хөдөөгийгхөнд боловсрол олгох ажлыг одоогийнхөө илүү өргөн хүрээтэй зөв зохион байгуулах шаардлагатай байна.

Байнга хүнд хөдөлмөр эрхэлдэг бүх улиралд гадаа голдуу ажилладаг малчин тариаланчид болон хөдөөгийнхөн амьжиргийн үйлчилгээ нэн чухал шаардлагатай зүйлийнх нь нэг мөн билээ. Эрүүл мэндийн хяналт болон хүн ам ауйн бодлого хөдөөд үндсэндээ алдагдахад хүрээд байна. Монгол хүний генийн санг хэвийн хадаглах талаар хөдөө орон нутгийг хийгдэж буй ажил, баримтлаж буй бодлого огт байхгүй байна. Үүний улмаас нилээд олон сум орон нутагт цус олртон болж улмаар оюун ухааны хомсдолтой хүүхдийн тоо өссөн байна. Энэ бол түгшүүртэй мэдээ юм. Монгол улсад 32000 оюун хомсдолтой хүн байгаагийн 24 хувь нь удамшлын гаралтай байна гэж нотлогдсон байгаа юм. Сэтгэц мэдрэл оюун ухааны хомсдол өвчний байдал дэлхийн түвшинд 1000 хүн тутамд 10 байгаа бол манай улсын дундаж үүнээс их байгаа төдийгүй зарим сумдынх 5 дахин их байна. Эмнэлэгийн үйлчилгээ төлбөртэй болсон нь бэлэн мөнгөгүй хөдөөгийнхөнд маш хүнд дарамт учруулж байгаа юм. Үүний улмаас амь насанд аюултай онцгой хүнд өвчнөөс бусад тохиолдолд эмнэлэг бэлэн эмчийн барааг харахгүй байна гэж хэлж болно. Хөнгөн үйлдвэрний салбарт тэргүүн байр эзлэх хэмжээнд хүрнээ хязгааргүйгээр үйлдвэрлэгдэн гарч буй архи дарс хил боомтоор оруулж ирж буй техникийн спирт зэрэг нь хөдөөгийнхөний төдийгүй нийт монголчуудын эрүүл мэндийг ноцтойгоор сүйтгэж байна. Спиртийг мөнгө төгрөг ховор хөдөөгийнхөн хямдыг харан авч шууд найруулан хэрэглэж байна шүү дээ. Оюуны хомсдолтой нийт хүмүүсийн 17,2 хувь эцэг өвчтэй архидалттай холбоотой байгаа юм. Иймд хөдөөгийнхний бэлэн мөнгөний хомсдолоос бага ч болов гаргах өөрсдийн эрүүл мэндийн төлөө, ирээдүй хойч үе, үр хүүхдийнхөө төлөө анхаарал тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх талаар анхаарч ажиллах цаг болсон мэт санагдана.

### 3. Мал сүрэг нутаг бэлчээрийн талаар:

Монгол мал сүрэг болон байгалийн бэлчээр нь манай орны мал аж ахуйн үйлдвэрлэлийн үндсэн хэрэгсэл юм. Хөдөөгийн малчин тариаланчид төдийгүй улсын маань эдийн засагт чухал үүрэгтэй монгол малын удмын сан болон эрүүл мэндийн хамгаалах асуудал төрийн бодлогын хувьд бүрхэг ээдрээтэй асуудлын нэг болжээ. Энэхүү асуудлыг " малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах ..." гэх мэт хууль гаргах төдийгөөр шийдэх бүс мэрэгжилтэй боловсон хүчнийг хөдөө рүү татах зорилгоор шийдвэрлэх ёстой гэж үзэж байна.

Манай бэлчээрийн нөөцийг авч үзвэл богт шилжүүлснээр 60 сая мал ямар саад бэрхшээлгүй бэлчих боломжтой тооцоо байдаг. Өнөөдөр малын тоо 32,9 сая буюу богт шилжүүлснээр 50 орчим саяд хүрээд байна. Иймд монголын малын хязгааргүйгээр өсгөхөөс түүний ашиг шимийн өгөөжийг дээшлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь илүү зохимжтой гэж үзэж байгаа юм. Нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлнэ гэдэг дан ганц эрлийзжүүлнэ гэсэн үг огт биш юм. Лам ч малыг өөрийн нь дасан зохицсон нэн зохистой бүс нутагт байршуулан маллах юм бол малчны ажиллагаа хөнгөвчлөгдөхийн зэрэгцээ малын өсөлт хөгжилт сайжирч, өвчлөлт хорогдолт багасаж ашиг шимийн өгөөж дээшлэн биологийн онцлогтой. Иймээс тухайн бүс нутгийн байгаль эдийн засгийн нөхцөлд тохирсон мал аж ахуйн цөөн салбарыг зөв хоршиж эрхлэх замаар үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой юм.

Хүний харэгцээ шаардлагыг хангасан мал аж ахуйн бүтээгдхүүн бэлтгэхэд мал сүргийн эрүүлжилтийн байдал онцгой чухал ач холбогдолтой байдаг. Юуны түрүүнд малаас хүнд дамжин халдварладаг өвчингүй эрүүл байх шаардлагатай юм. Мал сүргийг элдэв өвчнөөс хамгаалах, улмаар хүн ам нийтийн аюулгүй байдлыг хамгаалах үүрэг мал эмнэлэгийн байгууллагуудад ноогддог билээ. Энэ онцгой үүрэг хүлээсэн мал

эмнэлэгийн байгууллагынхаа бүтэц зохион байгуулалтыг байн байн өөрчилж, эцэст нь хувьчлах нэрийдлээр устаж үгүй болох аюул руу түлхэж байгаа нь нэн хачирхалтай санагдана. Жинхэнэ үйлчлүүлэгчид болох малчид нь бэлэн мөнгө нэг байхгүй төдийгүй 58 хувь нь 100 -аас доош малтай ядуучууд, 85,8 хувь нь 200 хүртэлх малтай дөнгөж өрхийн амьдралаа залгуулж байгаа дундчууд байгаа тохиолдол мал эмнэлэгийн байгууллага хувьчлагаад төлбөрт үйлчилгээний дээр тулгуурлан үйл ажиллагаагаа хэвийн явуулна гэдэг үнэхээр эргэлзээ төрүүлж байгаа юм. Зах зээлийн эдийн засагт шилжин хөрөнгө мөнгөний гачаалд орсон нэрээр мал эмнэлэгийн байгууллагын зохион байгуулдаг бүх шатанд бусниулсны уршгаар мал сүргийн дотор халдварт өвчнийг оношлох, эмчлэх, өвчнөөс сэргийлэх эрүүлжүүлэх, ариутгах халдваргүйжүүлэх, эрүүл ахуй ариун цэврийн байдлыг хянах цогц ажил унаж, дэгдэлт нь зогсож, тархалт халдварлалт нь хумигдан багасаж байсан халдварт өвчнүүд газар авах хандлагатай болж байна. Тухайлбал: 1998 оны үзүүлэлтүүд 1997 оныхтой харьцуулахад өвчнөөр хорогдсон малын тоо 7,3 мянгаар нэмэгдсэн төдийгүй зарим аймгуудад өвчнөөр хорогдсон мал нийт хорогдлын 54,3 хувиас 77,6 хувийг эзлэж байна гэсэн тооцоо гарч байна. Мал амьтны зарим халдварт өвчнүүд гарсны улмаас хүн өвчлөх нас барах тохиолдол гарсан, Европын орнуудад гаргах махны экспорт хаагдсан зэрэг сөрөг үр дагаварууд гарч ирсээр байна. Иймд мал сүргийн өвчинтэй тэмцэх, нийт хүн амын аюулгүй байдлыг сахин хамгаалах асуудал баталгаагүй болж буй нөхцөл байдлыг төр засаг анхааралдаа авах цаг нэгэнт болсон байна.

Нэг малаас авах ашиг шимийн үзүүлэлт ихээхэн доогуур байдаг учраас бэлчээрийг үнэ төлбөргүй ашиглаж байгаа гүнцгэн нөхцөл л монголын бэлчээрийн мал аж ахуйг бага зэргийн үр ашгитай байх боломж олгож байдаг билээ. Иймээс өдрийн өдөрт багассаар байгаа 118,2 сая га бэлчээрээ хамгаалах, зохистой хэмнэлттэй ашиглах асуудал төрийн бодлогын салбарыг нэгэн хэсэг байх ёстой юм. Бэлчээр талхлагдаж түүний өгөөж жилийн жилд буурсаар байна. Энэ асуудал хот суурин газарт ойрхон нутаг болон төвлөрсөн зам дагуух бүс нутгуудад бүр ч илүү хурцаар тавигдаж байгаа юм. Манай улсын нутаг дэвсгэрийг 70,7 хувь нь ховор устай мужид багтдаг. Гэтэл сүүлийн хоёр жилд инженерийн байгууламжтай 9,3 мянгаар худаг ажиллагаагүй болсон байна. Энэ нөхцөл байдал нь зарим бүс нутагт бэлчээрийг жигд, зохистой ашиглах боломжийг болгожээ. Ийм учраас бэлчээрийг усжуулж жигд ашиглах нөхцөл бүрдүүлэхэд туслаж дэмжих, төвлөрлийг сааруулах талаар хэрэгжихүйц бодитой ажил зохиох зэрэгт анхаарлаа хандуулах шаардлагатай байгаа юм.